

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

**Санамж:** Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/  
 ..... гэдэг нь тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо.  
 А. Тэгш бус байдал В. Нийгмийн давхраажилт С. Нийгмийн давхраа  
 D. Нийгмийн нийтлэг E. Нийгмийн ялгарал

2. Дараах ойлголтоос аль нь бурангүй үзлийг тодорхойлсон байна вэ? /1 оноо/  
 А. Нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хаах үйлдэл  
 В. Хүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлж байдаг.  
 С. Нэг бүлгийнхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлага  
 D. Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрэй зааглагдан хуваагдах ойлголт.  
 E. Эрэгтэй, эмэгтэй хүний нийгмийн бүтэц, соёлоос хамааран тодорхойлогдох ялгаа.

3. Дараах ойлголтуудын аль нь зөрчилдөөний онолын үзэл баримтлалд хамаарах вэ? /2 оноо/  
 А. Ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаанд хүргэх ба нийгмийг хөдөлгөгч хүч нь болдог.  
 В. Нийгмийн зөрчил нь ангийн ялгаанаас гадна шашин, үзэл суртлаас хамаардаг.  
 С. Тухайн зүйл нь юу болохыг өөрөө хэрхэн ойлгож, төсөөлж байгаадаа тулгуурладаг.  
 D. Ангийн ялгарлыг өмчийн гэхээсээ эрх мэдлийн ялгаатай түлхүү холбон үздэг.  
 E. Ажил мэргэжлийн нэр хүнд нь хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

4. Монголын социализмын үеийн нийгмийн давхраажилтын ангиллыг ялгаатай бүтэцтэй нь тохируулна уу. /2 оноо/

a	Ажилчдын	1	Босоо шатлалын дагуу эрх мэдэл, орлогын ялгаатай
b	Сэхээтний	2	Тээврийн, үйлчилгээний, аж үйлдвэрийн салбартай
c	Номенклатура	3	Нийтийн ба хоршооллын өмчлөлөөрөө ялгаатай

- A. a2, b1, c3      B. a1, b2, c3      C. a3, b1, c2      D. a3, b2, c1      E. a2, b3, c1

5. 2020-2023 оны “Зам тээврийн ослын бүртгэл” гэсэн баримт бичгээс хүүхдийн зам тээвэрт өртсөн хэсгийг сонгон, тус онуудын давтамж хоорондын хамаарлыг статистик шинжилгээ ашиглан шинжилсэн гэж үзвэл судалгааны аль арга вэ? /1 оноо/  
 А. Контент анализ      В. Туршилтын арга  
 С. Тоон судалгаа      D. Асуулга      E. Дедуц



6. Дараах бодомжуудаас бүтэц-чиг үүргийн онолыг нийгмийн судалгааны үүднээс тайлбарласныг олоорой. /1 оноо/
- A. Нийгэм нь хувь хүний хүсэл зоригоос үл хамаарах объектив мөн чанартай тул нийгмийн судалгаагаар нийгмийн бодит байдал дахь үзэгдэл хоорондын зүй тогтлыг илрүүлж чадна.
- B. Эрх мэдэлтэй хийгээд эрх мэдэл багатай хүмүүсийн харилцааны цаана оршин буй нийгмийн бодит байдлыг илрүүлэн өөрчлөх, сайжруулах боломжийг хайхаар нийгмийн судалгааг хийдэг гэж үздэг.
- C. Нийгмийн бодит байдлыг судлах нь хүмүүс хэрхэн харилцдаг, тэдгээр хүмүүсийн үйлдэлд илрэх утга учрыг тэдний нүдээр харж, ойлгох явдал гэж үзнэ.
- D. Нийгмийн бодит байдлыг объективоор судлах боломжгүй ч, далд оршин буй бодит байдлыг илрүүлэхийн тулд зонхилох тайлбарт захирагдалгүйгээр судлана гэж үздэг.
- E. Нийгмийн тухай ерөнхий онол гэж байх боломжгүй бөгөөд судлагдсан бодит байдлаар индукцийн аргын дагуу тодорхой түвшний онол бүтээх боломжтой гэж үздэг.
7. Нийгмийн судалгааны асуулгын арга нь 5 хэсэгтэй. Үүнээс удиртгал хэсэгт хамаарах өгөгдөл аль нь вэ? /1 оноо/
- A. Орон нутгийн нэр, огноо, мэдээлэл цуглуулагчийн нэр зэргийг тэмдэглэнэ
- B. Хувь хүний нийгмийн байр суурийг тодорхойлох асуултууд байна
- C. Судалгааны таамаглал, мэдээлэлд шаардлагатай туслах асуултууд байна
- D. Ямар зорилготой судалгааг, хаанаас явуулж байгаа тухай товч танилцуулга
- E. Судалгаанд оролцогчдын холбоо барих утас, хаягийн талаар мэдээлэл байна
8. Судалгааны нэр томьёо, ойлголтыг тохирох жишээ өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Дүн шинжилгээний нэгж	1	Нийслэлийн өрхийг судлах бол УБ хотын бүх өрх хамаарна.
b	Эх олонлог	2	УБ хотын бүх өрхийг хэмжих, шинжлэх хувь хүн, бүлэг, байгууллага зэргийг хэлнэ.
c	Нэлэнхүй судалгаа	3	УБ хотын бүх өрхийг хамруулах ба хүн ам, орон сууцны тооллого явуулах судалгаа

- A. a2, b3, c1      B. a1, b2, c3      C. a2, b1, c3      D. a3, b2, c1      E. a1, b3, c2

9. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- Уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэм болон өөрчлөгдөхийг..... гэнэ.
- A. Нийгмийн хувьсал      B. Нийгмийн шинэчлэл      C. Нийгмийн хувьсгал
- D. Нийгмийн хяналт      E. Нийгмийн гажуудал
10. “Нийгмийн өөрчлөлтийг нэг л хүчин зүйлээр тайлбарлах нь учир дутагдалтай, учир нь нийгэм өөрчлөгдөхөд эдийн засгийн адил төр, арми, шашин чухал үүрэг гүйцэтгэдэг” гэдэг нь хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/
- A. Г. Ленский, Ж. Ленский      B. К. Маркс      C. М. Вебер
- D. Т. Парсонс      E. Тённис
11. “Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаадаг цогц ойлголтыг соёл гэнэ” гэж үзсэн нь хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/
- A. Р.Бенедикт      B. А.Гидденс      C. Э.Тайлор      D. Э.Кассирер      E. Ж.Локк



12. Хуулийн ойлголтыг тохирох хуультай нь харгалзуулна уу.

/2 оноо/

a	Монгол хэлний тухай хууль	1	Соёлын үнэт зүйл гэдэгт эх хэл, уламжлалт технологи гэх мэт хамаарна.
b	Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	2	4 жил тутамд Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгоно гэж заажээ.
c	Монгол улсын Соёлын тухай хууль	3	Монголын түүх, соёл бол үндэсний аюулгүй байдлын дархлаа мөн

A. a2, b1, c3

B. a1, b2, c3

C. a2, b3, c1

D. a3, b2, c1

E. a1, b3, c2

13. “Дэлхийн бүх улс орнууд он солигдох мөчийг өөрийн үндэстний зан үйл, итгэл үнэмшил, ёс заншлын онцлогоор угтан хуучин оноо үдэж, шинэ оноо угтдаг” гэсэн нь соёлын аль ойлголтод хамаарах вэ?

/1 оноо/

A. Нэгдмэл шинж

B. Соёлын динамик

C. Сонгодог соёл

D. Түгээмэл шинж

E. Үндэсний соёл

14. Хүснэгт дэх мэдээллийг уншаад соёлын өвийн ангиллыг илэрхийлж байгаа хэсгийг сонгоорой.

/1 оноо/

A	Хүмүүсийн амьдралын хэв маягт онцгой ялгаа илэрдэггүй нь нэг хэв загварын соёлд хамаарна.
B	Морин хуур, балет, нийтийн дуу нь тус бүр соёлын ардын, нийтийн, сонгодог гэсэн ангилалд хамаарна.
C	Үндэсний соёлыг ангилах гол шалгуур нь зонхилогч ба дэд соёл болно.
D	Соёл нь хүй нэгдлийн, эртний, шинэ үеийн гэх мэт түүхэн цаг хугацааны хувьд ялгаатай оршдог.
E	Хадны зураг, археологийн дурсгал, морин хуур, уртын дуу, бие биелгээ нь биет ба биет бус соёлд хамаарна.

15. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэж тодорхой хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд хамаарах хүрээг ялгана уу.

/1 оноо/

- |                     |                            |                  |
|---------------------|----------------------------|------------------|
| 1. Кино урлаг       | 2. Уламжлалт анагаах ухаан | 3. Шинжлэх ухаан |
| 4. Техник технологи | 5. Тайзны уран бүтээл      |                  |

A. 2, 4

B. 4, 5


C. 2, 3

D. 1, 5

E. 3, 4



16. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмуудыг гүйцээгээрэй. /2 оноо/




- A. Иргэдийн авьяасыг нээн, хөгжүүлэх, таниулах боломжийг бий болгоно
- B. Улс орнуудыг соёл, ёс заншлаар нь ялган таниулах гол арга зам болгох
- C. Орон нутгийн хүн амын амжиргаа, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх
- D. Тухайн соёлын бусдаас ялгарах, дахин давтагдашгүй шинжийг нээх
- E. Иргэдийн оролцоо нь нийгмийг нягтруулж, бүлгийг хүчирхэг болгох

17. “Телевизийн олон суваг олон нийтийн ухамсарт таалагдаж, тэднийг байлдан дагуулахын тулд америкчлал, европчлол, өрнөдийн элдэв уриа лоозон дэвшүүлэн, халамжлагч ивээгчийн дүрээр халхавчлан зүсэн зүйлээр довтолж байна” гэсэн монгол судлаачийн дүгнэлт нь дараах ойлголтоос алийг түлхүү илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Соёлын дархлаа сулрах шалтгаан
- B. Соёлоо хадгалж үлдэх шалтгаан
- C. Соёлоо эрхэмлэхийн шалтгаан
- D. Соёлын суурь зарчмын шалтгаан
- E. Соёлын зөрчих хандлагын шалтгаан

18. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрийг гүйцээгээрэй. /2 оноо/



- A. Соёлыг хуулбарлан дуурайх
- B. Соёлын тулгалт
- C. Соёлын адилсал
- D. Соёлын солилцоо
- E. Соёлын орон зай

19. Дараах эрдэмтдийг тохирох үзэл баримтлалтай нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Ж. Локк	1	Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хургасан нэгэн болгодог.
b	Дж. Кэмпбелл	2	Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хясах явдал биш харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал юм.
c	Э. Фромм	3	Эрх чөлөө бол хүний амьдралын эрхэм зорилго, хувь хүний өөрийгөө нээх боломж юм.

- A. a2, b3, c1
- B. a1, b2, c3
- C. a2, b1, c3
- D. a3, b2, c1
- E. a1, b3, c2



20. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлох аргыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- A. ДНБ-ийг орлогоор тооцох  
B. ДНБ-ийг өнөөгийн үнээр тооцох  
C. ДНБ-ийг тогтмол үнээр тооцох  
D. ДНБ-ийг зардлаар тооцох  
E. Нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцох
21. Нийгэм, эдийн засгийн үзэгдэлд өсөлтийн хурдыг хувиар тооцоолоход үзүүлэлт нь 100-аас дээш утгатай бол ямар утгыг харуулах вэ? /1 оноо/
- A. Өсөлт, бууралт байхгүй  
B. 2 дахин хурдтай өссөн  
C. 2 дахин хурдтай буурсан  
D. Буурсан утгыг илэрхийлнэ  
E. Өссөн утгыг илэрхийлнэ
22. Дараах өгөгдлүүдийн аль нь мөнгө зээлийн бодлогын нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгод хамаарах вэ? /1 оноо/
- A. Хувь хүн болон ААН-ээс авах татварын хэмжээг бууруулах  
B. Төрийн өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохиох  
C. Засгийн газрын хөтөлбөр, төсөл боловсруулж зардлаа ихэсгэх  
D. Зээлийн хүүг бууруулж, гүйлгээнд байгаа мөнгийг өсгөх  
E. Эдийн засгийн уналтыг сааруулах, инфляцид нөлөөлдөггүй
23. 2023 онд Монгол улсын экспорт нь 490 тэрбум төгрөг, импорт нь 330 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны тэнцлийг тооцоолно уу. /1 оноо/
- A. 820                      B. -160                      C. 160                      D. - 820                      E. 410
24. Дараах эдийн засгийн ойлголтоос аль нь Ф. Хайекийн үзэл баримтлал вэ? /2 оноо/
- A. Эдийн засаг дахь зах зээлийн тогтолцоо нь уналтаас өөрийгөө аврахгүй.  
B. Эдийн засаг дахь төрийн идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна.  
C. Эдийн засагт төрийн оролцоо нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх гол арга зам юм.  
D. Эдийн засаг дахь уналт нь түүний онолыг батлаж, хямралаас гаргасан.  
E. Эдийн засаг дахь мөнгө, банкны онол нь банкны шинэчлэлд чухал үүрэгтэй.
25. Инфляцийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөлд үл хамаарахыг олно уу. /1 оноо/
- A. Бараа, үйлчилгээний нийт эрэлт муудна  
B. Бараа бүтээгдэхүүний үнэ өндөр өснө  
C. Зээлдүүлэгчдэд ашигтай нөхцөл бий болно  
D. Иргэдийн худалдан авах чадвар буурна  
E. Эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулна
26. Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин 600 мянган төгрөг болж өсөхөд хөдөлмөрийн нийлүүлэлт 500 нэгж байсан. Тэгвэл хөдөлмөрийн эрэлт 100 нэгж байхад ямар үзэгдэл бий болох вэ? /2 оноо/
- A. Ажиллах хүчний хомсдол бий болно (400 нэгжээр буурсан)  
B. Ажиллах хүчний илүүдэл бий болно (200 нэгжээр өссөн)  
C. Ажиллах хүчний хомсдол бий болно (200 нэгжээр буурсан)  
D. Ажиллах хүчний илүүдэл бий болно (400 нэгжээр өссөн)  
E. Ажиллах хүч илүүдэл бий болно (600 нэгжээр өссөн)



27. Дараах мэдээллийг уншаад, өгөгдсөн томъёоны дагуу тооцоолоорой. /2 оноо/  
Монгол улсын эдийн засаг 2021 онд 20 тэрбум байсан бол, 2022 онд 21.4 тэрбум болсон гэж үзвэл 2022 онд МУ-ын эдийн засаг хэдэн хувиар өссөн бэ?

$$\text{ЭЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан} - \text{ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$

- A. 1.4%      B. -7%      C. 7%      D. -1.4%      E. 20.5%
28. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/  
..... нь ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм.
- A. Хууль дээдлэх зарчим      B. Шударга байх зарчим      C. Нээлттэй зарчим  
D. Зөвшилцлийн зарчим      E. Цөөнхийг хүндэтгэх зарчим
29. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг харуулсан бүдүүвчийг ажиглаад алдаатай хэсгийн дугаарыг сонгоно уу. /2 оноо/

1. Иргэдийн төлөөлөгчдийн хурал

•Аймаг, нийслэлийн засаг дарга

2. Сум, дүүргийн засаг дарга

•Орон нутгийн агентлаг

3. Иргэдийн нийтийн хурал

•Баг, хорооны засаг дарга

- A. 3, 1      B. 3      C. 1      D. 2      E. 2, 3
30. Дараах өгөгдлөөс иргэний улс төр дэх хууль ёсны оролцоог ялгана уу. /1 оноо/

1. Сонгуульд санал өгөх

2. Улс төрийн шийдвэрийг дагахаас татгалзах

3. Эсэргүүцлийн жагсаалд оролцох

4. Нийгэм, улс төрийн амьдралд оролцох

- A. 1, 3      B. 1, 2      C. 2, 4      D. 2, 3      E. 1, 4
31. Сонгуулийн мажоритари тогтолцоог тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Энгийн олонх	1	50-аас дээш хувийн санал авсан дэвшигчийг ялсанд тооцдог
b	Харьцангуй олонх	2	Хамгийн олон санал авсан дэвшигчийг ялсанд тооцдог
c	Үнэмлэхүй олонх	3	Нийт саналын $\frac{3}{4}$ буюу 75% эсвэл $\frac{2}{3}$ буюу 66% дээш санал авсан дэвшигчийг ялсанд тооцно

- A. a2,b3,c1      B. a2,b1,c3      C. a1,b3,c2      D. a1,b2,c3      E. a3,b1,c2
32. Улс төр судлаач Г.Алмондын тодорхойлсон улс төрийн системийн гаралтын чиг үүрэгт хамаарах өгөгдлийг олно уу. /2 оноо/
- A. Хууль зүйн хэм хэмжээ, шийдвэр боловсруулах  
B. Улс төрийн нийгэмшилтийг хангах  
C. Нийгэм дэх бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах  
D. Явцуу олон шаардлагыг нэгтгэн боловсруулах  
E. Нам нь сонгуулиар дамжин төрийн эрх барих



33. Дараах өгөгдлөөс улс төрийн намын зорилгыг ялгаарай.

/2 оноо/

1. Иргэдийн улс төрийн хүсэл зорилгыг хэрэгжүүлэх
2. Улс төрчдийг бэлтгэн чадавхжуулж нэр дэвшүүлэх
3. Засгийн эрхийг авахын төлөө өрсөлдөх
4. Намын дотоод ардчиллыг хангах, бэхжүүлэх

- A. 1, 3                      B. 2, 4                      C. 2, 3                      D. 1, 2                      E. 3, 4

34. Чиний бодлоор дараах ойлголт нь ардчиллын ямар үнэт зүйлийг зөрчсөн байна вэ?

/2 оноо/

*Ардчилсан нийгэмд хаан, ерөнхийлөгч, сайд нар л хуулиас дээгүүр эрх мэдэлтэй, харин ард иргэд нь хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээнэ.*

- A. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс                      B. Иргэдийн улс төрийн оролцоо  
C. Олон намын тогтолцоо                      D. Хуулийн засаглал  
E. Тогтмол чөлөөт, шударга сонгууль

35. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.

/1 оноо/

..... бол иргэд төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэж чаддаг хүмүүсийн нэгдэл. Өөрөөр хэлбэл хүмүүс хамтран нэгдэж, үзэл бодлын хүрээгээрээ өөрсдөө зохион байгуулахыг хэлнэ.

- A. Лобби бүлэг                      B. Улс төрийн нам                      C. Иргэний нийгэм  
D. Сонирхлын бүлэг                      E. Улс төрийн институт

36. Сонирхлын бүлгийн үйл ажиллагаа нь түүний чиг үүргээр илэрдэг. Нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах нь аль чиг үүрэгт хамаарах вэ?

/1 оноо/

- A. Агрегаци                      B. Артикуляци                      C. Интеграци  
D. Интервенц                      E. Девальваци

37. Монгол улс нь олон улсын хамтын нийгэмлэгт оролцохдоо хэд хэдэн зарчмыг баримталдаг. Дараах ойлголтоос аль нь тэнцвэртэй байх зарчмыг илэрхийлж байна вэ?

/1 оноо/

- A. Гадаад харилцаандаа нөөц бололцоог бүрэн дайчлах, зохион байгуулах  
B. Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, хөгжлийг хэрэгжүүлэх  
C. Стратегийн зорилт, ач холбогдолтой улсуудын сонирхлыг тэнцвэржүүлэх  
D. Олон улс гүрэнтэй хамтран ажиллах, харилцааг олон хэлбэрээр явуулах  
E. Хөгжиж байгаа орнуудтай нийтлэг зорилгын үүднээс хамтран ажиллах

38. “Хүмүүс байгалиас заяасан эрх чөлөөтэй. Гэтэл яагаад төр засагт захируулж, эрх чөлөөгөө хязгаарлуулдаг юм бэ?” гэсэн асуултыг тавьж түүнд тодорхой хариултыг гаргаж үзэл бодлоо илэрхийлсэн сэтгэгч хэн бэ?

/1 оноо/

- A. Ж. Руссо                      B. Т.Гоббс                      C. Л.Актон                      D. Ж. Локк                      E. Р.Нозик

39. Засаг төрийн эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, эрх зүйт төрийн үндсийг бэхжүүлэх зэрэг нь аль ёсны үзэл баримтлалд хамаарах вэ?

/1 оноо/

- A. Төрийн албаны эрх зүйд захирагдах ёс                      B. Иргэний эрх зүйд захирагдах ёс  
C. Эрх зүйд захирагдах ёс                      D. Захиргааны эрх зүйд захирагдах ёс  
E. Үндсэн хуульт ёс





40. Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлд үл хамаарах жишээг олоорой. /2 оноо/
- A. Иргэн Т-ийн ажилладаг аж ахуйн нэгж татан буугдсан  
 B. Иргэн М нь албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон  
 C. Иргэн Л нь өндөр настны тэтгэвэр авах эрх үүссэн  
 D. Иргэн А нь сахилгын зөрчил гаргаж сануулах шийтгэл авсан  
 E. Иргэн Б нь томилолтоор өөр орон тооны ажилд ажиллах болсон
41. Сахилгын зөрчил гаргасан этгээдийн ажлаас халах шийтгэлийг хэдэн сарын дотор ноогдуулах ёстой вэ? /2 оноо/
- A. Зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 1 сарын дотор  
 B. Зөрчил гаргаснаас хойш 5 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 2 сарын дотор  
 C. Зөрчил гаргаснаас хойш 4 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 2 сарын дотор  
 D. Зөрчил гаргаснаас хойш 3 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 2 сарын дотор  
 E. Зөрчил гаргаснаас хойш 7 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 1 сарын дотор
42. Хүснэгт дэх өмчлөх эрхтэй холбоотой ойлголтуудыг ажиглаад 1, 2 хэсгийг харьцуулаад, аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Хэсэг	А. Өмчлөх эрх үүсэх үндэслэл	Б. Өмчлөх эрхээ хэрхэн хамгаалах вэ?	В. Өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн үйлдэл
1-р хэсэг	Эзэнгүй эд юмс олж авах нь хуульд заасан үндэслэл болно.	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргана.	Эд хөрөнгө устгах гэмтээх
2-р хэсэг	Зээлийн гэрээгээр өмчтэй болох нь гэрээнд заасан үндэслэл болно.	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гаргана.	Залилах, хулгайлах

- A. 1-р хэсгийн А  
 B. 1-р хэсгийн В  
 C. 2-р хэсгийн А  
 D. 2-р хэсгийн Б  
 E. 2-р хэсгийн В

43. Бат 14 настай бөгөөд хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцож болох уу? /2 оноо/
- A. Бат өөрийн хүсэлтээр ажил эрхлэх сонирхолтой бол хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.  
 B. Бат нь 14 настай тул иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай гэсэн үндэслэлээр хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцох боломжгүй.  
 C. Бат нь эцэг эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр мэргэжлийн чиг баримжаа, ажлын дадлага олох зорилгоор хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.  
 D. Бат нь 14 настай тул иргэний эрх зүйн заримдаг чадамжтай гэсэн үндэслэлээр хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцох боломжгүй.  
 E. Монгол улсын иргэн бүр өөрийн хүсэлтээр насны хязгаарлалтгүй ажил эрхлэх боломжтой.





44. Бүрэн тэтгэврийн хэмжээг хэрхэн тооцдог вэ? /1 оноо/
- A. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч буюу төрийн албан хаагчид сүүлийн 12 сарын цалингийн дунджийн 100 хувиар тооцно.
  - B. Тухайн даатгуулагчид тогтоогдвол зохих сарын тэтгэврийг шимтгэл төлбөл зохих нийт сарын тоонд хувааж шимтгэл төлсөн нийт сарын тоогоор үржүүлж тооцно.
  - C. Тухайн даатгуулагчид тогтоогдвол зохих сарын тэтгэврийг шимтгэл төлбөл зохих нийт сарын тоонд үржүүлж шимтгэл төлсөн нийт сарын тоогоор хувааж тооцно.
  - D. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж хөдөлмөрийн хөлсний 45 хувиар тооцно.
  - E. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт гэрээгээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй гэж тооцно.

45. Иргэнд захиргааны байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзвал 2 үе шатаар шийдвэрлүүлэх эрхтэй. 1-р үе шатад иргэн байгууллагатай харилцах аль хэлбэр хамаарахыг сонгоорой.

/2 оноо/

1-р шат .....	2-р шат Захиргааны хэргийн шүүхэд хандах
---------------	--

- A. Захиргааны байгууллагын дараагийн шатны байгууллагад өргөдөл гаргах
- B. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан магадлал гаргах
- C. Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандан нэхэмжлэл гаргах
- D. Дээд албан тушаалтанд нь хандан амаар болон бичгээр хүсэлт гаргах
- E. Дээд албан тушаалтанд нь хандан амаар болон бичгээр гомдол гаргах

46. Дараах тодорхойлолтоос эрх зүйн зөрчил гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?

/1 оноо/

- A. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл эс үйлдлийг хэлнэ.
- B. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.
- C. Нийгэмд хор аюултай, эрүүгийн хуулиас бусад хууль зөрчсөн гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.
- D. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг хэлнэ.
- E. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй нийцэх төлвийг хэлнэ.

47. Аймаг, нийслэлийн засаг дарга эрх зүйн ямар акт гаргадаг вэ?

/1 оноо/

- A. Тушаал                      B. Захирамж                      C. Шийдвэр                      D. Тогтоол                      E. Зарлиг

48. Цэгийн оронд тохирох оныг сонгоорой.


/1 оноо/

Монгол улс бүрэн улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд Де-факто улс байх статусыг ..... он хүртэл эдэлж байсан.

- A. 1989 он                      B. 1945 он                      C. 1948 он                      D. 1961 он                      E. 1990 он




49. Олон улсын харилцааны улс оролцогчдыг дотор нь их гүрэн, дунд улс, бага улс хэмээн ангилдаг. Их гүрнийг илэрхийлсэн тодорхойлолтыг сонгоорой. /1 оноо/  
 А. Олон улсын харилцаанд нөлөө багатай ч дэлхий улсуудын 2/3 нь энэ ангилалд багтдаг  
 В. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг.  
 С. Бүс нутагтаа нөлөөтэй, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.  
 D. Өөрийн болон хөрш, холбоотон, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах чадалтай байдаг.  
 E. Өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй.
50. Дараах өгөгдлүүдээс аль нь Монгол улсын хоёр талын харилцаа, оролцооны үйл ажиллагаа вэ? /1 оноо/  
 А. Гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээний улс орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа.  
 В. Ази номхон далайн бүс нутгийн олон талт үйл явц, яриа хэлэлцээр интеграцид үр ашигтай оролцох үйл ажиллагаа.  
 С. Монгол улсаас олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, олон талт харилцаа, түншлэл, дипломат үйл ажиллагаа.  
 D. Зүүн хойт Ази, Төв Азийн олон талт үйл явц, интеграцид үр ашигтай оролцох үйл ажиллагаа.  
 E. Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал.
51. Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй. /2 оноо/



- А. а-Стратегийн түншлэл, б-Энэтхэг  
 В. а-Иж бүрэн стратегийн түншлэл, б-БНХАУ  
 С. а-Стратегийн түншлэл, б-БНСУ  
 D. а-Иж бүрэн түншлэл, б-АНУ  
 E. а-Өргөн хүрээтэй түншлэл, б-Австрали

52. Гуравдагч хөрш орнуудтай дипломат харилцаа тогтоосон оныг өгсөх эрэмбэд оруулна уу. /2 оноо/



- А. 4, 3, 1, 2      В. 2, 3, 4, 1      С. 3, 2, 1, 4      D. 2, 3, 1, 4      E. 3, 2, 4, 1

53. “Олон улсын харилцааны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг” гэж үздэг онолыг нэрлэнэ үү. /1 оноо/  
 А. Неолиберал онол      В. Неореалист онол      С. Либерал онол  
 D. Реалист онол      E. Марксист онол



54. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны цар хүрээний бүдүүвчийг гүйцээгээрэй.

/2 оноо/



A. a-АСЕАН, b-АСЕМ  
D. a-НАТО, b-НҮБ

B. a-ШХАБ, b-АПЕК  
E. a-ЕХ, b-АПЕК

C. a-НАТО, b-ШХАБ

55. Олон улсын харилцааны хатуу хүчний бодлогын үйлдлийн төрлийг сонгоно уу. /1 оноо/

- A. Захирах чадвар      B. Урамшуулал      C. Удирдамж  
D. Үнэмшил            E. Цэргийн хүч

56. АНУ-ын эрдэмтэн Жозеф Самуэль Най, эрдэмтэн Роберт Коэхэнтэй хамтран 1977 онд олон улсын харилцааны неолиберал онолын чиглэлээр “Хүч чадавх ба харилцан хамаарал” гэсэн бүтээлээ туурвисан. Энэхүү бүтээлд хамаарах үзэл санааг ялгаарай.

/2 оноо/

1. Хатуу, зөөлөн хүчний ялгааг тайлбарласан
2. Соёлын дипломат харилцааг тайлбарласан
3. Зөөлөн хүчний онолыг анх удаа дэвшүүлсэн
4. Гуравдагч хөршийн бодлогыг дэвшүүлсэн

- A. 1, 2                      B. 1, 3                      C. 2, 4                      D. 3, 4                      E. 2, 3

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. ДНБ-ий үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.

/5 оноо/

a	Бодит ДНБ	1	Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
b	Нэрлэсэн ДНБ	2	Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг өнөөгийн үнээр тооцохыг хэлнэ
c	Үндэсний нийт бүтээгдэхүүн	3	Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг тогтмол үнээр тооцох үзүүлэлт
d	Дотоодын нийт бүтээгдэхүүн	4	Тухайн оны ДНБ-ийг өмнөх оны ДНБ-д харьцуулаад 100 хувьд үржүүлж тооцоолно.
e	ДНБ-ийн өсөлтийг тооцох	5	Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүн



2.2. Д. Истоны улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

a	Шаардлага	1	Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
b	Оролцооны дэмжлэг	2	Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд
c	Бодит дэмжлэг	3	Нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдэг онцлогтой
d	Шийдвэр	4	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт
e	Эргэх холбоо	5	Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх

2.3. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх хугацааг харгалзуулна уу.

/5 оноо/

a	Гомдол хүлээн авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш нийслэлд ..... дотор улсын дээд шүүхэд хүргүүлнэ.	1	30 хоног
b	Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ..... дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.	2	90 хоног
c	Хэрэг үүссэн өдрөөс хойш орон нутагт ..... дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна.	3	14 хоног
d	Давж заалдах гомдол гаргасан хэргийг, давж заалдах шүүх хүлээн авснаас хойш ..... дотор хянан шийдвэрлэнэ.	4	3 хоног
e	Зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаа хэтэрсэн тохиолдолд гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойш ..... дотор нөхөн сэргээнэ.	5	7 хоног

2.4. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.

/5 оноо/

a	UNDP	1	НҮБ-ын “Хөгжлийн хөтөлбөр”
b	UNESCO	2	Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
c	АСЕАН	3	НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага”
d	АПЕК	4	Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо
e	АСЕМ	5	Ази-Европын уулзалт

